

**РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

51

2015 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын даргын 2015 оны 102 тоот тушаал, “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын үйлдвэрийн газрын харьяа аймгуудын газрын үйл ажиллагааны журмыг нэгдүгээр хавсалтаар баталсугай.
2. Дээрх журмыг мөрдлөг болгон ажиллахыг Өмнөговь аймгийн радио, телевизийн сүлжээний газрын дарга, Хөвсгөл аймгийн радио, телевизийн сүлжээний газрын дарга, Говь-Алтай аймгийн радио, телевизийн сүлжээний газрын дарга, Дорнод аймгийн радио, телевизийн сүлжээний газрын дарга, Баян Өлгий аймгийн радио, телевизийн сүлжээний газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий удирдлагын хэлтсийн дарга / Г.Нямгэрэл /-д үүрэг болгосугай.



Ч.ОЮУНБААТАР



“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ” УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХАРЬЯА АЙМГУУДЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Уг журам нь “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын харьяа аймгуудын радио, телевизийн газар (цаашид газар гэх) үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, газрын эд хөрөнгийн эрх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын харьяа газрууд дагаж мөрднө.
- 1.3. Уг журамд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, шинэчлэн найруулах асуудлыг Газрын захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 1.4. Энэхүү журмыг “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын харьяа газрууд журам батлагдсан өдрөөс эхэлж дагаж мөрднө.

ХОЁР. “РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ГАЗРУУДЫН ОНООСОН НЭР

- 2.1 Өмнөговь аймгийн радио, телевизийн сүлжээний газар
- 2.2 Хөвсгөл аймгийн радио, телевизийн сүлжээний газар
- 2.3 Говь-Алтай аймгийн радио, телевизийн сүлжээний газар
- 2.4 Дорнод аймгийн радио, телевизийн сүлжээний газар
- 2.5 Баян Өлгий аймгийн радио, телевизийн сүлжээний газар

- ### ГУРАВ. “РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ГАЗРУУДЫН БЭЛГЭДЭЛ, ТЭМДЭГ
- 3.1 Газар нь өөрийн бэлэгдэл /эмблем/-тэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
 - 3.2 Бэлэгдэл /эмблем/-ийн загварыг “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг харьяа газрууд эдэлнэ.
 - 3.3 Тэмдэгээр харьяа газруудын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.
 - 3.4 Тэмдгийг харьяа газрын даргаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

ДӨРӨВ. ХАРЬЯА ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

- 4.1 Өмнөд бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог болон тоон технологийг өндөр түвшинд гологдол сааталгүй дамжуулах, радио телевизийн станцуудын тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах, гарсан гэмтлийг шуурхай илрүүлж засварлана. Өмнөд бүсийн радио телевизийн сүлжээний тогтвортой найдвартай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Өмнөговь, Дундговь аймаг дахь инженер техникийн ажилтнуудыг шуурхай удирдлагаар хангах.

- 4.2 Төвийн бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог болон тоон технологийгэндөр түвшинд гологдол сааталгүй дамжуулах, радио телевизийн станцуудын тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах, гарсан гэмтлийг шуурхай илрүүлж засварлана. Төвийн бүсийн радио телевизийн сүлжээний тогтвортой найдвартай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Хөвсгөл, Завхан аймаг дахь инженер техникийн ажилтнуудыг шуурхай удирдлагаар хангах.
- 4.3 Баруун бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог болон тоон технологийгэндөр түвшинд гологдол сааталгүй дамжуулах, радио телевизийн станцуудын тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах, гарсан гэмтлийг шуурхай илрүүлж засварлана. Баруун бүсийн радио телевизийн сүлжээний тогтвортой найдвартай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Говь-Алтай, Баянхонгор аймаг дахь инженер техникийн ажилтнуудыг шуурхай удирдлагаар хангах.
- 4.4 Зүүн бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог болон тоон технологийгэндөр түвшинд гологдол сааталгүй дамжуулах, радио телевизийн станцуудын тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах, гарсан гэмтлийг шуурхай илрүүлж засварлана. Зүүн бүсийн радио телевизийн сүлжээний тогтвортой найдвартай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Дорнод Сүхбаатар аймаг дахь инженер техникийн ажилтнуудыг шуурхай удирдлагаар хангах.
- 4.5 Баруун бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн бүсийн аймаг, сумын төвүүдэд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог болон тоон технологийгэндөр түвшинд гологдол сааталгүй дамжуулах, радио телевизийн станцуудын тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах, гарсан гэмтлийг шуурхай илрүүлж засварлана. Баруун бүсийн радио телевизийн сүлжээний тогтвортой найдвартай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Баян-Өлгий, Увс, Ховд аймаг дахь инженер техникийн ажилтнуудыг шуурхай удирдлагаар хангах.

ТАВ. ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Газар нь дор дурьдсан эрхтэй байна. Үүнд:
- 5.1.1 "PTYC" УТҮГ-ын захирлын хяналтанд өөрт олгогдсон үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах.
- 5.1.2 "PTYC" УТҮГ-ын захирлын хяналтанд шаардлагатай техник, хэрэгсэл, сэлбэг, материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гадаад, дотоодын нийлүүлэгчээс гэрээ байгуулан худалдан авах.
- 5.1.3 "PTYC" УТҮГ-ын захирлын хяналтанд Монгол Улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагуудтай эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах.
- 5.2 Газар нь дор дурьдсан үүрэгтэй байна. Үүнд:
- 5.2.1 "PTYC" УТҮГ-ын захирлын хяналтанд Монгол Улсын хууль тогтоомж болон байгууллагын дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах;
- 5.2.2 "PTYC" УТҮГ-ын захирлын хяналтанд Радио, телевизийн нэвтрүүлэг дамжуулах, дахин дамжуулах үндсэн үүргийг биелүүлэх шаардлагатай техникийн найдвартай ажиллагааг хангах, технологийн болон хөдөлмөрийн сахилга батыг байгууллагын дотоодод чанд сахиулах;

- 5.2.3 “PTYC” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ХЯНАЛТАНД УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙГ, САР, УЛИРАЛ, ЖИЛЭЭР БАТЛАГДСАН ЗАРДЛЫН ХУВААРИЙН ДАГУУ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛАХ;
- 5.2.4 Радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах;
- 5.2.5 “PTYC” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ХЯНАЛТАНД САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ ШИНЭЧЛЭХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ШИНЭ ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЭХ:

ЗУРГАА. ГАЗРЫН УДИРДЛАГА

- 6.1 “PTYC” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ХЯНАЛТАНД ГАЗРЫН ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГАЗРЫН ДАРГА УДИРДАНА. ГАЗРЫН ДАРГЫГ “Радио телевизийн үндэсний сүлжээ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ ТОМИЛЖ, ЧӨЛӨӨЛНӨ.
- 6.2 Газрын дарга нь байгууллагын дүрэм, энэхүү журамд заасан эрх хэмжээний дотор газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 6.3 Газрын дарга нь дор дурьдсан эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 6.3.1 “PTYC” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ХЯНАЛТАНД ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЛИЦЕНЗ, ЭРХИЙН ХОЛБОГОДХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭН АЖИЛЛАХ.
 - 6.3.2 “PTYC” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ХЯНАЛТАНД ГАЗРЫН АЖИЛЧИДТАЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАН АЖИЛД ТОМИЛЖ, АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ ОЛГОХ, САХИЛГЫН ШИЙТГЭЛ НОГДУУЛАХ.
 - 6.3.3 Ерөнхий нягтлангийн хяналтанда анхан шатны бүртгэл хөтлөлт, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах зэрэг ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг биечлэн хариуцах.
- 6.4 Газрын дарга нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
 - 6.4.1 Газрын техник, технологийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, энэ салбарт 5-аас доошгүй жил дагнан ажилласан, радио холбооны бакалавраас доошгүй зэрэгтэй, удирдлагын зохих мэдлэг, дадлага, туршлагатай байх.
- 6.5 Газрын дарга нь гэрээгээр хүлээсэн үүргээ биеүүлээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол түүнийг ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

ДОЛОО. ГАЗРЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 7.1 Газрын эрх бүхий албан тушаалтан нь “PTYC” УТҮГ-ЫН ЖУРАМД ЗААСАН ҮҮРГИЙГ БИЕЛҮҮЛЖ, БАЙГУУЛЛАГЫН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ҮНЭНЧ ШУДАРГААР АЖИЛЛАНА. “PTYC” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ЗӨВШӨӨРСНӨӨС БУСАД ТОХИОЛДОЛД БАЙГУУЛЛАГЫН НУУЦ, ДОТООД МЭДЭЭЛЛИЙГ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ДАМЖУУЛАХ, ХУВИЙН АШИГ СОНИРХОЛД АШИГЛАХЫГ ХОРИГЛОНО.
- 7.2 Эрх бүхий албан тушаалтан нь санаатайгаар хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас “PTYC” УТҮГ-Т ХОХИРОЛ УЧРУУЛСАН БОЛ ХОХИРЛЫГ ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ХАРИУЦНА.

НАЙМ. ГАЗРЫН САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР, САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТЭНЦЭЛ БҮРТГЭЛ

- 1 Газрын санхүүгийн жил нь "PTYC" УТҮГ-ын санхүүгийн жилтэй ижил байх
бичвэд тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12-р сарын
31-ний өдөр дуусгавар болно.
- 2 Газрын санхүүгийн алба нь эд хөрөнгийн дотоодын тооллогыг хугацаанд нь
наалжжилж тайлангаа жилийн тайллан тэнцэлд тусгана.
- 3 Газар санхүүгийн тайлангаа жилийн эцэст "PTYC" УТҮГ-ын захирал, ерөнхий
нягтлан бодогчид тайлагнана.
- 4 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг газрын дарга, ахлах нягтлан бодогч нар
хариуцна.

ЕС.ХАРЬЯА ГАЗРЫН ХЯНАЛТ

- 1 "PTYC" УТҮГ-ын захирлын хяналтанд газрын дарга нь өмч хөрөнгийн
хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион
байгуулж, түүний үр дүнг удирдах дээд байгууллагын өмнө хариуцна.
- 2 Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналтыг ахлах
нягтлан бодогч хариуцна.

АРАВ. БУСАД

- 10.1 Энэ журамд тусгагдсанаас бусад асуудлыг Үйлдвэрийн газрын дүрэм болон
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн
дагуу зохицуулна.

_____ооо_____